БАТЛАВ:
ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА
Ж.БУЯНБАТ

2023 оны 03 дугаар сарын 01-ны өдөр

# ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Зорилго | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн үзүүлэлт | Хугацаа | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх. | 1.1.Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл боловсруулж, батлуулах. | Төлөвлөгөөг батлуулсан эсэх. | 1 дүгээр улиралд | ЗУГ |
| | | 1.2.Батлагдсан төлөвлөгөөг нэгжүүдэд хүргүүлж, хэрэгжилт үр дүнг тооцох. | Нэгжүүдэд хүргүүлж, хэрэгжилт, үр дүнг тооцож, тайланг ХЗДХЯ, АТГ-т хүргүүлсэн байх. | Хагас, бүтэц жилд | ЗУГ, нэгжийн дарга нар |
| | | 1.3.АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг боломжит хэлбэрээр алба хаагч, олон нийтэд хүргэсэн байх. | Баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байх. | Тухай бүр | ЗУГ, нэгжийн дарга нар |
| | | 1.4.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах. | -Хууль тогтоомжийг цахим хуудсанд байршуулах, өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа гэх мэт соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх.<br>-Үр дүнг тооцож тайлагнасан байх. | Жилдээ | ЭШСХТ, нэгжийн дарга нар |
| | | 1.5.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах. | -Мэдээллийг тогтмол шинэчлэх.<br>-Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх. | Сар бүр | ЗУГ, нэгжийн дарга нар |
| | | 1.6.Авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины | -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл албан ёсны цахим хуудас болон лед дэлгэц, сурталчилгааны | Жилдээ | ЗУГ, нэгжийн дарга нар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нийтлэл, радио контент, цахим хэвлэмэл ном, гарын авлага гэх мэт) сурталчилгааг алба хаагч, олон нийтэд хүргэсэн байх. | самбарт байршуулах.<br>-Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх. | | |
| | | 1.7.Шинээр томилогдсон алба хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулах. | -Шинэ томилогдсон алба хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад хамруулсан байх.<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | ЭШСХТ, нэгжийн дарга нар |
| 2 | Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох. | 2.1.Шүүх шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж хэвших. | -Байгууллагын бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх.<br>-Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх.<br>-Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах.<br>-Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх. | Тухай бүр | СХГ, ЗУГ, нэгжийн дарга нар |
| | | 2.2.“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх. | -Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх;<br>-Сургалт, мэдээлэл авсан байх,<br>-Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх. | Тухай бүр | СХГ, АБДХАГ, ХНХ, нэгжийн дарга нар |
| | | 2.3.Авлигын эсрэг хууль тогтоомж, дүрэм, журам болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг мэдээллийн самбар болон цахим хуудсанд байршуулж, тогтмол сурталчлах. | Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах. | Тухай бүр | ЗУГ |
| | | 2.4.Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах.<br>/тухай бүр шинэчилсэн байх/ | Сул орон тооны зарыг байгууллагын цахим хуудсанд байршуулах. | Тухай бүр | ХНХ |
| 3 | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг | 3.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх. (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол | -Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх.<br>-Тайланд нотломжийг хавсаргасан | Жилдээ | АБДХАГ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | арилгуулах арга хэмжээ авах. | мэдээлэлд дүн шинжилгээ хийж асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м) | байх. | | |
| | | 3.2.Авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох хүнд суртлыг бууруулах чиглэлээр уулзалт, хэлэлцүүлэгт оролцох. | Уулзалт, хэлэлцүүлэгт оролцсон байх. | Эхний 9 сард | ЭШСХТ, нэгжийн дарга нар |
| | | 3.3.Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авах. | Судалгааг авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж холбогдох арга хэмжээг зохион байгуулах. | Эхний хагас жилд | ХНХ, нэгжийн дарга нар |
| | | 3.4.Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө /төлөвлөгөөт/-г цахим хуудсандаа байршуулсан байх. | Хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг баталж, цахим хуудсандаа байршуулах. | 1 дүгээр улиралд | АБДХАГ |
| | | 3.5.Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлсэн байх. | Цахим хуудсаар мэдээлсэн байх. | Хагас, бүтэн жилд | АБДХАГ |
| | | 3.6.Иргэдийн өргөдөл, гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн талаар мэдээлэх. | Өргөдөл гомдлын тайлан, мэдээг ил тод мэдээлэх. | Хагас, бүтэн жилд | АБДХАГ |
| 4 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл санаачилга өрнүүлэх. | 4.1.Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдад танилцуулах. | -Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх.<br>-Алба хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх.<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | ЗУГ, нэгжийн дарга нар |
| | | 4.2.Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах. | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 49 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах. | Жилдээ | ЗУГ, нэгжийн дарга нар |
| | | 4.3.Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгах. | -Санал тусгасан байх.<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | АБДХАГ |
| | | 4.4.Төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг цахим хуудсандаа байршуулах. | Мэдээллийг цаг тухайд нь байршуулж, баяжуулсан байх. | Хагас, бүтэн жилд | ЗУГ, нэгжийн дарга нар |
| | | 4.5.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион | Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх. | Тухай бүр | АБДХАГ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байгуулсан арга хэмжээ. | | | |
| | | 4.6.Өргөдөл гомдол, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх. /утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр/ | Иргэдийн саналыг авч саналын дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах. | Тухай бүр | АБДХАГ |
| | | 4.7.Иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах. | Иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах. | 1-р улиралд | ЗУГ |
| 5 | Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх. | 5.1.Төсөв, санхүүгийн тайланг сар, улирал жилээр хугацаанд нь гаргаж холбогдох дээд байгууллагад тайлагнах. | Тайлан, мэдээ хуулийн хугацаанд холбогдох дээд шатны байгууллагад хүргэгдэж, төсвийн зарцуулалтын талаарх мэдээг нийтэд ил тод мэдээлэх. | Улирал бүр | СХГ, НШШГ, АШШХ |
| | | 5.2.Тухайн жилийн төсөв. | | 1-р сарын 10-ны дотор | |
| | | 5.3.Өмнөх оны төсвийн гүйцэтгэл. | | 4-р сарын 1-ний дотор | |
| | | 5.4.Сарын төсвийн гүйцэтгэл. | | Дараа сарын 8-ны дотор | |
| | | 5.5.Улирлын төсвийн гүйцэтгэл. | | Дараа сарын 8-ны дотор | |
| | | 5.6.Хагас жилийн төсвийн гүйцэтгэл. | | 8-р сарын 15-ны дотор | |
| | | 5.7.Хагас жилийн санхүүгийн тайлан | | 8-р сарын 15-ны дотор | |
| | | 5.8.Дараа жилийн төсвийн төсөл. | | 8-р сарын 15-ны дотор | |
| | | 5.9.Жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хуудсанд байршуулах. | | 4-р сарын 1-ний дотор | |
| | | 5.10.Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт. | | 4-р сарын 25-ны дотор | |
| | | 5.11.Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ. | | 7-р сарын 1-ний дотор | |
| | | 5.12.Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар. | | Улирал бүр | |
| | | 5.13.Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт /өөрчлөлт орсноос хойш ажлын 7 хоногийн дотор/. | | Тогтоосон хугацаанд | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 5.14.Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ. | | Тухай бүр | |
| | | 5.15.Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт. | | Гүйлгээ хийснээс хойш 7 хоногийн дотор | |
| | | 5.16.Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт. | | Өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор | |
| | | 5.17.Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл. | | Тухай бүр | |
| 6 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах. | 6.1.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулах. | Байгууллагын худалдан авах ажиллагаа, тендерийн талаарх мэдээ, мэдээлэл бусад холбогдох материалыг цахим хуудсанд байршуулах. | Тухай бүр | СХГ, НШШГ, АШШХ |
| | | 6.2.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам /тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт/, тендерийн урилгыг цахим хуудсанд байршуулах. | | Тухай бүр | |
| | | 6.3.Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл шалтгааныг цахим хуудсанд байршуулах. | | Тухай бүр | |
| | | 6.4.Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсанд байршуулах. | | Тухай бүр | |
| 7 | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах. | 7.1.Боловсон хүчнийг сэлгэн ажиллуулах. | Сэлгэн ажиллуулсан байх. | Тухай бүр | ХНХ, нэгжийн дарга нар |
| | | 7.2.Албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигатай холбоотой аливаа асуудлыг эрх бүхий албан тушаалтанд мэдээлэх. | Мэдээллийг нэн даруй мэдэгдсэн байх. | Тухай бүр | АБДХАГ, нэгжийн дарга нар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 7.3.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ. | Зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг зохион байгуулах. | Тухай бүр | АБДХАГ, нэгжийн дарга нар |
| | | 7.4.Албан тушаалын тодорхойлолт болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар тусгах. | Албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан байх. | Эхний хагас жилд | ХНХ, нэгжийн дарга нар |
| | | 7.5.Албан хаагчдын "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг"-ийг бүрдүүлэлтийн программд нэгтгэж, тайланг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлэх. | Тайланг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлсэн байх. | 1-р улиралд | ЗУГ |
| | | 7.6.Хуульд заасны дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалд томилогдсон этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, лавлагаа авч асуудлыг шийдвэрлэх. | АТГ-т хүргүүлж, лавлагаа авч томилгоог хийх. | Тухай бүр | ХНХ |

Хянасан:
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Э.ХАЛИУНБАЯР

Боловсруулсан:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ЦАГДААГИЙН ХОШУУЧ Б.АМАР